

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баяндун сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2026/028/НА-СТА-ОНТС

<p>Цахим хуудас: https://audit.mn/ Чойбалсан хот 2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 70584207, Цахим хаяг: Narmandakh@audit.gov.mn Аудитор: Б.Оюунхэрлэн Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.02.25 № 230
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.БАТЖАВ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засаг дарга үнэлээгүй байна.

2126050117



Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	232,460,476.48	245,091,561.48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	141,660,151.48	47,575,026.63
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	141,660,151.48	47,575,026.63
3121	Төгрөг	141,660,151.48	47,575,026.63
31211	Төрийн сангийн харилцах	141,660,151.48	47,575,026.63
33	АВЛАГА	90,800,325.00	197,516,534.85
335	Бусад авлага	90,800,325.00	197,516,534.85
33510	Байгууллагаас авах авлага	-	144,757,787.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	90,800,325.00	52,758,747.85
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	232,460,476.48	245,091,561.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	232,460,476.48	245,091,561.48
51	Засгийн газрын хувь оролцоо	232,460,476.48	245,091,561.48
512	Хуримтлагдсан үр дүн	232,460,476.48	245,091,561.48
51210	Өмнөх үеийн үр дүн	226,069,469.48	232,460,476.48
51220	Тайлант үеийн үр дүн	6,391,007.00	12,631,085.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	232,460,476.48	245,091,561.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,541,007.00	13,381,085.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,541,007.00	13,381,085.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,541,007.00	13,381,085.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,541,007.00	13,381,085.00
1200046	Зээлийн хүүгийн орлого	6,541,007.00	13,381,085.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	150,000.00	750,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,000.00	750,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.00	750,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.00	750,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,391,007.00	12,631,085.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,391,007.00	12,631,085.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	39,377,575.35	39,464,375.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,377,575.35	39,464,375.15
120	Нийтлэг татварын бус орлого	39,377,575.35	39,464,375.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,377,575.35	39,464,375.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,377,575.35	39,464,375.15
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	150,000.00	750,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,000.00	750,000.00

Баяндун сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.00	750,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.00	750,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	39,227,575.35	38,714,375.15
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	132,799,500.00
230001	Эргэж төлөгдөх зээл	-	132,799,500.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(132,799,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	39,227,575.35	(94,085,124.85)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	102,432,576.13	141,660,151.48
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	141,660,151.48	47,575,026.63

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	226,069,469.48	226,069,469.48
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,069,469.48	226,069,469.48
C07	Тайлант үеийн үр дүн	6,391,007.00	6,391,007.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,460,476.48	232,460,476.48
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	232,460,476.48	232,460,476.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,460,476.48	232,460,476.48
D08	Тайлант үеийн үр дүн	12,631,085.00	12,631,085.00
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,091,561.48	245,091,561.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		141,660,151.48
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,000,000.00	133,549,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,000,000.00	750,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,000,000.00	750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	750,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	750,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	133,000,000.00	132,799,500.00
230001	Эргэж төлөгдөх зээл	133,000,000.00	132,799,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	39,464,375.15
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	39,464,375.15
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	39,464,375.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		47,575,026.63

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар 132.8 сая төгрөгийн 1 алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Сангаас олгосон эргэж төлөгдөх зээлийг авлагад бүртгээгүй, үр дүнгийн тайланд зардлаар тусгасныг залруулсан.

Аудитаар нийт 40.3 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 албан шаардлага өгсөн.

3.1 Албан шаардлага

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлтэй, тайлант онд төлөлт хийгээгүй 3 иргэн байна. Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ; гэж заасныг хэрэгжүүлээгүй байна. Өмнөх аудитаар тухайн асуудлаар зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 40.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 38.0 сая төгрөгөөр давсан ч материаллаг бус тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлтэй 3 иргэн огт төлөлт хийгээгүй байна.	1	40,289.2			1	40,289.2		
Дүн	1	40,289.2			1	40,289.2		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		᠎	᠎	
		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баяндун сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			